

## ЭХ ОРОН НАМЫН УЛС ТӨРИЙН ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2008-05-16

Дугаар ...19...

Улаанбаатар хот

Эх орон намын 2008 оны хоёрдугаар сарын 01-ний өдөр хуралдсан зургаадугаар Бага чуулганаас байгуулагдсан ажлын хэсгийн боловсруулсан саналыг үндэслэн **ТОГТООХ** нь:

Нэг. 2008 оны УИХ-ын сонгуульд оролцох мөрийн хөтөлбөрийг 1-р хавсралтаар баталсугай.

Хоёр. Мөрийн хөтөлбөрийг сонгогчдод сурталчилж, хэвлэн нийтлүүлэх ажлыг зохион байгуулахыг Ерөнхий нарийн бичгийн дарга Н.Чулуунбаатарт даалгасугай.

Гурав. Сонгуулийн төв штабт ажиллах бүрэлдэхүүн, ажил үүргийн хуваарийг хавсралт 2-оор баталсугай.



Б.ЭРДЭНЭБАТ

Н.ЧУЛУУНБААТАР

Эх орон намын УТЗ-ийн  
2008 оны 5 сарын 16-ны өдрийн  
19 тоот тогтоолын 1-р хавсралт

Уриа: **ӨӨРТӨӨ ИТГЭЖ, ӨӨРСДӨӨ ХИЙЦГЭЭ**

## УИХ-ЫН 2008 ОНЫ СОНГУУЛЬД ӨРОЛЦӨХ ЭХ ОРОН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

*Манай нам Эх орныхоо тусгаар тогтнол, хүний хөгжлийг дээдлэн, шинэ үеийн соёл иргэншилт нийгмийг цогцлоон байгуулахын төлөө байна.*

Эх орон намд итгэл үзүүлснээр:

- Үндэсний эв нэгдлийг эрхэмлэж, ард түмнийхээ өөртөө итгэх итгэлийг сэргээнэ.
- Төрийн тогтолцоог боловсронгуй болгож, авилга, хээл хахууль, албан тушаалын гэмт хэргийг таслан зогсооно.
- Эдийн засгийн эрс шинэчлэлийн бодлогоор улс орноо бүсчлэн хөгжүүлнэ.
- Дотоод гадаадын хөрөнгө оруулагчдыг татварын бодлогоор дэмжиж, мал аж ахуй, газар тариаланг эрчимжүүлэн, эрдэс баялагийг зохистой ашиглах замаар үндэсний үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлнэ
- 180 мянгаас доошгүй ажлын байр шинээр бий болгож ядуурлыг зогсооно.
- Улаанбаатарыг хүн амьдрахад тааламжтэй эрүүл хот болгоно
- Хүн амын өсөлтийг эдийн засгийн хөшүүргээр урамшуулж, эх нялхасыг хамгаалах тогтолцоог бүрдүүлнэ

## НӨГ. УЛС ОРИЫ ӨНОӨГИЙН НОХЦӨЛ БАЙДАЛ

Өнгөрсөн 20 жилд Монгол оронд ардчилал, хүний эрх, эрх чөлөө бодит зүйл болсон хэдий ч нийт хүн амын амжиргааны түвшин илэрхий дээшилээгүйн улмаас эдийн засгийн эрх чөлөө бүрэн баталгаажиж чадаагүй байна. Монгол орны бийгалийн баялагийн асар их нөөц лиценз хэлбэрээр гадаадын компаниудын мэдэлд шилжиж тэр хирээр манай орон түүхий эдийн хавсарга төдий орон болж өгө нь улс орны эдийн засгийн тусгаар тогтнолд аюул үзүүлэх хэмжээнд хүрэхэд өйргөсөн байна.

Засаглалд улс төр, эдийн засгийн бүлэглэлүүдийн нөлөөлөх нөлөө хирээс хэтэрч улс орны чухал асуудлуудыг нам дамжсан бүлэглэлүүд шийдвэрлэдэг болсон нь нууц биш болжээ.

Дэлхийн хүнсний хямрал Монгол улсыг тойрч өнгөрөхгүй болох нь тодорхой болоод байна. Үнийн өсөлт, ард түмний амьжиргааны түвшинг улам бүр цордуулсаар байна. Бий болсон нөхцөл байдалд хариу болгож төрийн бодлогын шуурхай арга хэмжээ авах шаардлагатай байгаа боловч тийм чадамж илтэд дутагдаж байна. Хүисний аюулгүй байдал, үндэсний байдлыг хангах үүднээс

горийн хүлээх үүрэг, хариуцлагыг шинээр харах шаардлагатай байна. Иймд Монголын төрийг шинэчлэх цаг болсон гэж Эх орон нам үзэж байна.

## Хоёр. ЭДИЙН ЗАСГИЙН ЗӨРИЛТ

*Эх орон нам үндэсний үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлнэ*

### 2.1 ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

2.1.1 Хүний хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн Монгол улсын Зүүн, баруун, Дунд, Төв бүсэд экспортын баримжаатай өмчийн олон хэлбэрт суурилсан үйлдвэрлэлийг жигд хөгжүүлэх замаар бүс нутаг бүрт эдийн засгийн хувьд бүрэн биеэ даах нөхцөл боломжийг бүрдүүлж 2012 он гэхэд ДНБ-ний жилийн дундаж өсөлтийг одоогийнхоос 2 дахин, аж үйлдвэрийн нийт бүтээгдхүүний үйлдвэрлэлийн хэмжээг 1,5-2 дахин нэмэгдүүлнэ.

2.1.2 Дотоодын үйлдвэрлэлийг дэмжиж, хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний хангамжийг нэмэгдүүлж, үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийн ханшийг тогтворжуулж, инфляцийн түвшинг нэг оронтой тоонд барина.

2.1.3 Хувийн хэвшлийн жижиг, дунд үйлдвэрлэл хөгжих улс төр, эрх зүй, эдийн засгийн таатай нөхцөлийг бүрдүүлнэ

2.1.4 Экспортыг нэмэгдүүлж, гадаад худалдааны тэнцлийг сайжруулна.

2.1.5 Бүс нутгийн эдийн засгийн чадамжийг нэмэгдүүлж, өөрийгөө санхүүжүүлэх зарчимд шилжүүлэх замаар төсвийн алдагдлыг бууруулна. Улсын төсвийн зардлын бүтцийг оновчтой богино.

2.1.6 Бүсчлэн хөгжүүлэх бодлоготой уялдуулан татварын бодлогод дараах өөрчилөлтийг оруулна. Үүнд:

- Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, дотоодын зах зээлийг гадаадын чанаргүй бараа, бүтээгдхүүнээс хамгаалах, үйлдвэрлэлд орчин үеийн техник технологи нэвтрүүлэх сонирхлыг урамшуулах зорилгоор импортын барааны гаалийн татварыг ялгавартай тогтооно.
- олон улсын стандартын шаардлага хангасан бүтээгдхүүн үйлдвэрлэсэн тохиолдолд татварын хөнгөлөлт үзүүлнэ
- Дотоод гадаадын хөрөнгө оруулагчдыг татварын адил тэгш нөхцөлөөр хангана
- Мал аж ахуйн түүхий эд боловсруулах үйлдвэрийг дэмжих зорилгоор экспортын татварын хэмжээг өөрчилөн шинэчилнэ.
- Бүс нутгийн байршлаас хамааран бараа, үйлчилгээний үнэ, тариф, цалин тэтгэвэр гүйгэмжийн сүлжээг ялгавартай тогтоож, татварын бодлогоор зохицуулна.
- Ашигт малтмалын нөөц, байгалийн баялаг ашигласны төлбөрийг улсын төсөвт, харин орон нутагт ажиллаж байгаа уурхай, үйлдвэрийн газрын орлогын татварыг тухайн аймаг, сумын төсөвт төвлөрүүлэх бодлого баримтална. Ашигт малтмалын төрөл, орд газрын тогтоц, ашиглалтын нөхцөлийг харгалзан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хэмжээг ялгавартай тогтооно.

2.1.7 Гадаадын зээл тусламжийн үр ашгийг дээшлүүлэх, төсвийн орлогын бүрдэлт, зарцуулалтад хяналт тавьж, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хаих зорилгоор Засгийн газрын хөрөнгө оруулалтын банк байгуулна.

2.1.8 Төв банкнаас арилжааны банкны үйл ажиллагаанд тавих хяналтын тогтолцоог боловсронгуй болгож, хадгаламж эзэмшигч болон харилцагч байгууллагын мөнгөн хөрөнгийг эрсдлээс хамгаална.

2.1.9 Төрийн өмчийн ашиглалт, хамгаалалт, үр ашгийг дээшлүүлэх, хувьчилах оновчтой хувилбарыг боловсруулж хэрэгжүүлнэ.

2.1.10 Стратегийн ач холбогдол бүхий томоохон аж ахуйн нэгжүүдийг төрийн мэдэлд байлган менежментийг нь сайжруулна.

## 2.2 ДЭД БҮТЭЦ

*Эдийн засгийн бүс нутгуудыг авто зам, эрчим хүч, харилцаа холбооны найдвартай нэгдсэн сүлжээнд холбоно.*

2.2.1 Баруун бүсэд: Эрдэнэбүрэн, Майхантолгойн УЦС-ыг, ашиглалтад оруулна

2.2.2 Дунд бүсэд: Хөвсгөлийн Чаргайтын УЦС-ыг ашиглалтад оруулж Баянхонгор аймагт ДЦС барих ажлыг эхлүүлнэ.

2.2.3 Төв бүсэд: Тавантолгой, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайг түшиглүүлэн 20,0 мянган МВт-ын хүчин чадалтай ДЦС байгуулах ажлыг эхлүүлнэ.

2.2.4 Төвийн эрчим хүчний системийн найдвартай ажиллагааг хангах зорилгоор Эгийн голын УЦС-ыг барж байгуулах ажлыг эхлүүлнэ.

2.2.5 Зүүн бүсэд: Атомын цахилгаан станц барих ТЭЗҮ-г боловсруулж ажлыг эхлүүлнэ.

2.2.6 Говь, тал хээрийн бүс нутагт нар, салхины эрчим хүчийг өргөнөөр ашиглана.

2.2.7 Аймаг бүрт өмчийн олон хэлбэрт суурилсан зам гүүрийн ажил эрхлэх байгууллагын үйл ажиллагааг тогтмолжуулж замын арчилалт үйлчилгээг тэднээр хийлгэх ажлыг дэмжин урамшуулна.

2.2.8 Хэвтээ тэнхлэгт Өвөрхангай-Баянхонгор-Говь-Алтай-ховд-Баян-Өлгийн зам, Хархорин-Цэцэрлэг-Тосонцэгэл-Улиастай-Увсын зам, Хэнтий-Дорнод аймгуудыг холбосон хатуу хучилттай зам, Босоо тэнхлэгт БНХАУ-Ярант-Ховдын зам, Замын-Үүд-Улаанбаатар-Алтанбулагийн өндөр хурдны зам, ОХУ-Ханх-Хатгал-Моронгийн олон улсын аялал жуулчлалын замыг ашиглалтад оруулна.

2.2.9 Алтанбулаг-Улаанбаатар-Замын үүд чиглэлээр хос төмөр замтай болох ТЭЗҮ-г боловсруулж ажлыг эхлүүлэх, бусад улс орон нутгийн чанартай төмөр замын сүлжээний нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэх, төмөр замд техникийн шинэчлэлийг үе шаттайгаар хийнэ.

2.2.10 Далайд гарцгүй орнуудад хөнгөлөлт үзүүлэх олон улсын эрх зүйн хүрээнд Монгол улс Гадаад далайн баялагаас хувь хүртэхасуудлыг олон улсын байгууллагад тавьж шийдүүлэх, далайн тээвэрт аялж байгаа Монгол улсын далайгаар хөлөг онгоцуудын үр өгөөжийг дээшлүүлэх цогц арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

2.2.11 Интернетийн сүлжээг айл бүрт хүргэнэ.

## 2.3 АЖ ҮЙЛДВЭР

*Бүс нутаг бүрийг тэнцвэртэй хөгжүүлэх бодлоготой уялдуулан улс орны эдийн засгийн чадамжийг дээшлүүлж экспортыг нэмэгдүүлэх, аж үйлдвэрийг эрчимтэй хөгжүүлэх зорилт тавьж байна.*

- 2.3.1 Уул уурхайн үйлдвэрлэлийг Архангай, Өвөрхангай, Хөвсгөл, Булган, Төв, Хэнтий, Завхан аймгуудад хязгаарлаж, байгаль хамгаалах, газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого баримтална.
- 2.3.2 Тавантолгой, Оюутолгой, Цагаансуврага, Мардай, Шивээ овоогийн ордыг аж ахуйн эргэлтэд оруулах шийдвэрийг яаралтай гаргана.
- 2.3.3 Үйлдвэрлэл технологийн паркийг Улаанбаатар/Хан-Уул, Багахангай, Багануур, Налайх/ Эрдэнэт, Дархан хотуудад байгуулах. Цаашид эдийн засгийн бүсүүдийн төвүүд, чөлөөт бүсүүдэд үе шаттайгаар байгуулна.
- 2.3.4 Спирт, Архины бүх үйлдвэрүүдийг төрийн онцгой мэдэлд авна
- 2.3.5 Хүнсний өргөн хэрэглээний болон, импортоор авч байгаа өргөн хэрэглээний бараа бүтээгдхүүн үйлдвэрлэх 10,0 мянган жижиг үйлдвэрийг бүх шатны төрийн захиргааны байгууллага, төрийн бус байгууллага, бизнес эрхлэгчдийн санаачилга, захиалга, ХАҮТ зэрэг төрөлжсөн мэргэжлийн байгууллагуудын санал дүгнэлтийг үндэслэн оруулж ирж бүх сум суурин газруудад тараан байршуулж ажиллуулна. Энэхүү арга хэмжээтэй холбогдуулж зээл, татварын цогц бодлого бловсруулж хэрэгжүүлнэ.
- 2.3.6 Импортыг орлох, экспортод шинээр гаргах бүтээгхүүн үйлдвэрлэх аж ахуйн нэг байгууллагуудад хөнгөлөлттэй зээлийн бодлогоор дэмжинэ.
- 2.3.7 Дарханы хар төмөрлөгийн үйлдвэр, Эрдэнэт үйлдвэрийг түшиглүүлэн хар болон өнгөт металл боловсруулах үйлдэрлэлийг хөгжүүлнэ.
- 2.3.8 Эрдэс түүхий эдийн байршлаас хамаарч эдийн засгийн бүс бүрт цемент, төмөр бетон, тоосго, хүрмэн блокны үйлдвэрийг барьж байгуулна.
- 2.3.9 Барилгын материлын үйлдвэрлэлийн хүчин чадлыг 3-4 дахин нэмэгдүүлнэ.
- 2.3.10 Мах, ноос ноолуур, арьс шир боловсруулж экспортын эцсийн бүтээгдхүүн хийх орчин үеийн технологитой үйлдвэрийн наркыг Дархан, Налайх, Багануур, Багахангай, Дорнод, Ховд, Завханд байгуулна.
- 2.3.11 Баруун бүсийн Олон булаг, Хөшөөт, Хөв булаг, Зээгт, Дунд бүсийн Нарийн сухайт, тэвшийн говь, Зүүн бүсийн Шивээ-Овоо, Тал булгийн нүүрсний уурхайг түшиглүүлэн нүүрсийг гүн боловсруулах /шингэрүүлж хийжүүлсэн түлшний/ үйлдвэр барих ТЭЗҮ-г боловсруулж ашиглалтад оруулна.

## 2.4 БАЙГАЛЬ ОРЧИН

- 2.4.1 Байгаль орчныг зөвхөн сэргээн ашиглах зарчмыг баримтална.
- 2.4.2 Байгаль орчны тэнцвэрт байдалыг хадгалж хөрсний эвдрэл, цөлжилт, хээрийн гүймэр зэргээс урьдчилан сэргийлнэ.

2.4.3 Ус агаар хөрсний бохирдлоос урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

2.4.4 Гадны байгууллага, сонирхогч иргэдийн өргөн оролцоотойгоор ойжуулах төсөл хэрэгжүүлэхийг төрөөс дэмжижнэ.

2.4.5 Байгалийн баялаг, ашигт малтмал олборлож байгаа аж ахуйн нэгжүүдээс “Байгалийн нөхөн сэргээлтийн сан” бүрдүүлнэ.

2.4.6 Байгаль хамгаалахад нутгийн иргэдийн хяналт, оролцоог урамшуулахад чиглэгдсэн цогц бодлого авч хэрэгжүүлнэ.

2.4.7 Байгаль хамгаалах, уул уурхайн нөхөн сэргээлтийг хийх, хяналт тавихад төрийн бус байгууллагууд, иргэдийн сайн дурын хөдөлгөөнүүд оролцож байх хууль эрх зүйн орчин бүрдүүлнэ.

## **2.5 МАЛ АЖ АХУЙ**

*Мал аж ахуйн салбарт үр ашгийг дээшлүүлэх явдлыг гол зорилт болгон тавьж байна.*

2.5.1 Бэлчээрийн даацад тохирсон ашиг шим сайтай мал аж ахуйг хөгжүүлэх сонирхлыг малчидад бий болгох чиглэлээр төрөөс бодлого боловсруулан хэрэгжүүлнэ.

2.5.2 Нутгийн шилмэл омгийн мал сонгон үржүүлж, сүү, мах, ноос, ноолуурын чиглэлийн үүлдрийг түлхүү өсгөн мал аж ахуйн бүтээгдхүүний тоо хэмжээ чанарыг нэмэгдүүлнэ.

2.5.3 Монгол орны онцлогт тохирсон зоо, мал эмнэлэгийн оновчтой бүтэцийг бий болгоно.

2.5.4 Тахиа, гахай, зөгий, загасны аж ахуйг хөгжүүлж, хүнсний дотоодын бүтээгдхүүний нэр төрлийг олшруулж, дээрхи нэр төрлийн бүтээгдхүүний импортыг орлох үйлдвэрлэлийг дэмжижнэ.

2.5.5 Мал аж ахуйн салбарт зах зээлийн нөхцөлд зохицсон шинэ хэлбэрийн фермерийн болон хоршсон аж ахуй байгуулах санаачилгыг бүх талаар дэмжинэ.

2.5.6 Жилд 1,5-2,0 сая тн хадлан бэлтгэж малын тэжээл тариалах ажлыг өрчимжүүлэн, мал сүргийг байгалийн эрсдэлээс хамгаална. Бэлчээрийг усжуулах ажлыг төрийн бодлогоор дэмжинэ.

2.5.7 Мянгат малчдыг мэдээлэл, арга ажиллагаа, зээл санхүүгийн бодлогоор дэмжиж сум орон нутгийн үйлдвэрлэгч, бэлтгэи нийлүүлэгч голлох аж ахуйнууд болгох бодлогыг хэрэгжүүлнэ.

## **2.6 ГАЗАР ТАРИАЛАН**

*Ух орны үйлдвэрийн гурил, хүнсний ногоогоор дотоодын хэрэгцээг бүрэн хангах зорилт тавьж байна.*

2.6.1 2012 он гэхэд газар тариалангийн эргэлтийн талбай, га-гаас авах ургацын хэмжээг 2 дахин нэмэгдүүлж жилд дунджаар 550-600 мянган тонн үр тариа хураан авч дотоодын хэрэгцээний гурлыг бүрэн хангана.

2.6.2 Манай оронд нутагшсан болон нутагших чадвартай сортын үрийн санг бий болгоно.

2.6.3 Тариалангийн зориулалттай газрыг Монгол улсын иргэдэд удаан хугацаагаар өмшүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

2.6.4 Төмс хүнсний ногоогоор дотоодын хэрэгцээг бүрэн хангана

2.6.5 Усалгаат тариаланг хөгжүүлнэ

## **2.7 АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ**

*Аялал жуулчлалыг төсвийн орлогыг бүрдүүлэхэд томоохон хувь нэмэр оруулдаг салбар болгон хөгжүүлэх зорилт тавьж байна.*

2.7.1 Аялал жуулчлалын үйлчилгээний чанар стандартыг дэлхийн түвшинд хүргэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

2.7.2 Аялал жуулчлал дахь улирлын нөлөөллийг арилгаж өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого баримтална.

2.7.3 Аялал жуулчлалын салбарт шинэ бүтээгдхүүн нийлүүлэх аж ахуйн нэгжүүдийг татвар, зээлийн бодлогоор урамшуулж дэмжинэ

2.7.4 Аялал жуулчлалын гол бүсүүд болох Хөвсгөл, Өмнөговь, Хархорум, Архангай, Хэнтий, Улаанбаатар, Тэрэлж орчмын бүс нутагт байнгын үйлчилгээний амралт, аялал жуулчлалын томоохон цогцолбор барих ажлыг дэмжинэ.

2.7.8 Говь-Алтай, Завхан, Ховд, Баян-Өлгий, Увс, Сүхбаатар аймгуудад аялал жуулчлалыг хөгжүүлэхийг урамшуулна

2.7.9 ОХУ-ын Байгаль нуур орчмоор ирж байгаа жуулчдыг Хөвсгөлд аялуулах, БНХАУ-аар дамжин өнгөрч байгаа жуулчдын урсгалын тодорхой хэсгийг Улаанбаатараар дамжин өнгөрөх нөхцөлийг бүрдүүлэхэд онцгой анхаарна.

2.7.10 2012 он гэхэд Монгол орон жилд 1,0 сая жуулчин хүлээж авах хүчин чадлыг бий болгоно.

## **3.1 ГУРАВ. НИЙГМИЙН ЗОРИЛТ**

*Эх орон нам ядуурлыг зогсоож, хүн амын дийлэнхи хэсэгийг чинээлэг дундаж давхрагын түвшинд хүргэхийг эрмэлзэнэ.*

**Монгол улсын хөгжлийн гол эх сурвалж хийгээд туйлын зорилго нь хүний хөгжил мөн. Хүн ам мэдлэг боловсролтой, эрүүл энх, боломжийн орлоготой байх нь хүний хөгжлийг хангах чухал нөхцөл гэж үзэж байна.**

3.1.1 Хүүхдэд 6-16 насаид багш төвтэй сургалтаар, 16-18 насанд мэргэжлийн сургалтаар бүрэн дунд боловсрол заавал олгох тогтолцоонд шилжинэ.

3.1.2 Бүх шатны сургуульд үндэсний соёл, ёс заншлын мэдлэг, хүмүүжил олгох, суралцагсдад эх оронч үзэл төлөвшүүлэхэд онцгой анхаарна.

3.1.3 Багш бэлтгэх, тэдний мэргэжилийг дээшлүүлэх тогтолцоог сургууль, аймаг бүүс нутаг, улсын хэмжээний гэсэн бүтэцтэйгээр бий болгон тасралтгүй ажиллагааг нь хангана.

3.1.4 Дээд боловсролын шинэчлэлийг гүнзгийрүүлэн, олон улсад хүлээн ившөөрөгдөх сургалт явуулах дэс дараатай арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

3.1.5 Техникийн болон нарийн мэргэжлийн боловсролыг хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн шинэчлэн хөгжүүлэх бодлого баримтална.

3.1.6 Сургуулийн өмнөх боловсрол, цэцэрлэгийн хүрэлцээ хангамжийг сайжруулж Улаанбаатар хотод хороо бүрт, хөдөө аймаг сумдад баг бүрт цэцэрлэг байгуулах ажлыг дэмжинэ. Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг төрөөс бүрэн санхүүжүүлнэ.

3.1.7 Боловсрол дахь хувийн хэвшлийн оролцоог татварын бодлогоор дэмжиж, нийтлэг мөрдөж байгаа стандартын шалгуулаар үнэлгээ өгч, чанар муутай сургалтаас иргэдээ хамгаална.

3.1.8 Оюуны өндөр чадамжтай, гоц авьяас билэгтэй оюутан сурагчдад төрөөс дэмжлэг үзүүлж сурах орчин нөхцөлөөр хангана.

3.1.9 Дээд боловсролын зардлыг төрөөс санхүүжүүлнэ.

3.1.10 Улаанбаатар хотын төвд байгаа улсын болон хувийн хэвшлийн сургуулиудыг хотын төвөөс гаргаж сургууль, спорт, соёл урлагийн төв, багш ажилчдын орон сууц, оюутны дотуур байр бүхий иж бүрэн хотхонуудыг байгуулна.

3.1.11 Дэлхийн нэр хүндтэй их дээд сургуулийн салбарыг байгуулах явдлыг дэмжинэ.

3.1.12 Бүх шатны сургууль цэцэрлэгийн барилга, тоног төхөөрөмж, тавилга хэрэгслэл, сургалтын орчинг сайжруулахад чиглэгдсэн хөрөнгө оруулалтыг эрс нэмэгдүүлж, сургалтын тохилог орчин бүрдүүлнэ

## 3.2 ЭРҮҮЛ МЭНД

*Хүн амын дундаж наслалтыг 3-5 жилээр уртасгах зорилт тавьж байна.*

3.2.1 Иргэдийг жилд нэг удаа 100 хувь эмнэлэгийн үзлэгт хамруулна. Иргэд өөрсдөө эрүүл мэндийнхээ төлөө хүлээх хариуцлагыг дээшлүүлэх цогц арга хэмжээ авна.

3.2.2 Хүн амын амьдралын ахуй нөхцөлийг сажруулан, ундны ус, хүнсний чанарыг дээшлүүлэх замаар ард иргэдийн эрүүл мэндийг хамгаална.

3.2.3 Архи, тамхи хэрэглэх болон бусад хорт зуршлын эсрэг өргөн хүрээтэй ажил зохион байгуулж, архи тамхины үйлвэрлэл, импортод онцгой хяналт тогтооно.

3.2.4 Төрөлтийг дэмжих эдийн засгийн бодлогыг төрөөс авч хэрэгжүүлнэ. Сум бүрт төрөхийн өмнөх, дараах амралт, сувилгааны газрыг сэргээн тохижуулна. Эх нилхасын эндэгдлийг зогсоох зорилт тавина.

3.2.5 Хүн амын дунд өргөн тархсан сүрьеэ, шар, бруцеллез, бэлгийн замын халдварт өвчин зэргийг бууруулах, улмаар арилгах ажлыг зохион байгуулна.

3.2.6 Хамгийн сүүлийн үеийн тоног төхөөрөмжтэй оиошилгоо, эмчилгээний төвийг аймаг бүрт байгуулж, орон нутагт эмизлэгийн нарийн мэргэжлийн тусламж, өвчнөөс урьдчилан сэргийлэх үйлчилгээг цоо шинэ шатанд гаргаана.



3.2.7 Эмч мэргэжилтнийг хөдөө орон нутагт тогтвор сууршилтай ажиллуулах эдийн засгийн урамшууллын механизм бий болгоно.

3.2.8 Ардын уламжлалт анагаах ухааны үр нөлөөтэй аргуудыг орчин үеийн анагаах ухаантай зохистой хослуулан хөгжүүлэх бодлого баримталж, эмийн үйлдвэрлэлийг өргөжүүлнэ.

3.2.9 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд төрийн бус байгууллагын оролцоо, гүйцэтгэх үүргийг өргөжүүлж, өмчийн олон хэвшилд суурилсан эрүүл мэндийн байгууллагын тогтолцоог бүрдүүлнэ.

3.2.10 Бүх хүнийг эрүүл мэндийн даатгалд хамруулах бодлого баримталж, даатгалын тогтолцоог боловсрогуй болгоно.

**3.3 СОЁЛ УРЛАГ, ШАШИН**

*Нүүдэлчний овөрмөц нандин соёл, урлагийн өвийг хадгалан орчин цагийн ололтвор баяжуулан хөгжсжүүлэх зорилт тавьж байна.*

3.3.1 Хөдөөд соёл түгэн хөгжих нохцол болоцоог бүрдүүлэн соёлын экспорт, жуулчлалын олон хэлбэрийг дэмжин хөгжүүлнэ.

3.3.2 Сонгодог болон хүүхдэд зориулсан урлагийг төрөөс дэмжин хөгжүүлнэ.

3.3.3 Түүх соёлын дурсгалт зүйлс, ардын урлаг, шинжлэх ухаан, мэдлэгийн үнэт өв, дэвшилтэт зан заншлыг үндэсний онцгой баялаг гэж үзэн төрийн хамгаалалтад байлгана.

3.3.4 Ардын дуу хөгжим, тоглоом наадгай, урлаг болон уран дарханы арга зэрэг соёлын өвийг хадгалан өвлүүлнэ.

3.3.5 Номын сан, музейн сан хөмрөгийг арвижуулан үйлчилгээний шинэ хэлбэр, хадгалалт хамгаалалтын шинэ технологийг үе шаттай нэвтрүүлнэ.

3.3.6 Уран бүтээлчдийн ховор, нандин, онцгой бүтээл туурвилыг төр худалдан авч холбогдох музей, галларейд хадгалж хамгаалах ажлыг дэмжинэ.

3.3.7 Ард түмнийхээ үе дамжин шүтэж ирсэн уламжлалт шашинаа хүндэтгэж, хөнхилох үүргийг нь хүлээн зөвшөөрнө.

**3.4 ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГН**

Шинжлэх ухааны нэгэнт бүрэлдсэн чадамжийг хадгалан, өсгөн хөгжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлж, эрдэм шинжилгээний ажилд их дээд сургуулиуд, эрдэмтэн мэргэдийн оролцоог өргөжүүлэх эрх зүй, эдийн засгийн хөшүүрэг бий болгоно.

3.4.1 Шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлүүдийг улс орны бүсчилэн хөгжүүлэх үзэл баримтлал, бүтцийн бодлогод нийцүүлэн шинэчлэн тодорхойлж, суурь болон хавсрага судалгаанд зарцуулах хөрөнгийн зохистой харьцааг тогтооно.

3.4.2 Эрдэмтэд, эрдэм шинжилгээний ажилтан, судлаачдын үр бүтээлтэй ажиллах нохцол болоцоо, нийгмийн баталгааг хангаж, оюуны болон материаллаг бүтээмжийн үр дүнгээр цалинжуулж урамшуулах зарчмыг хэрэгжүүлнэ.

3.4.3 Шинжлэх ухаан, үйлдвэрлэл, боловсролын уялдаа холбоог оновчтой болгож, шинжлэх ухааны тэргүүлэх чиглэлээр нарийн мэргэшсэн судлаачид бэлтгэх, залуу эрдэмтдийг дэмжих арга хэмжээ авна.

3.4.4 Шинжлэх ухаан, технологийн мэдээллийн нэгдсэн сүлжээ, сан бүрдүүлж горийн хамгаалалтад авна.

### **3.5 АЖЛЫН БАЙР, ОРЛОГО, ЦАЛИН**

3.5.1 2012 он гэхэд ажилгүйдлийг бууруулж 180,0 мянган ажлын байр шинээр бий болгож цаашид ажилгүйдлийг арилгана.

3.5.2 Цалинг үнэ хаашийн өсөлт, улс орны эдийн засгийн чадамжийг харгалзан шат дараатайгаар нэмэгдүүлэх бодлого баримтална.

3.5.3 Төрийн албаны болон, төрийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн сүлжээг тооцохдоо бүсчилсэн байдлаар ялгавартай тогтоож алслагдсан бүс нутгууд, говийн болон онцгой хүнд нөхцлийн нэмэгдэл гэх мэтээр ялгавартай тогтооно.

3.5.4 Амжиргааны баталгаажих түвшинг жил бүр шинэчлэн тогтоож байна.

3.5.5 Уул уурхайн салбарт ажиллаж байгаа Монгол мэргэжилтнүүд, ажилчдын цалинг ижил түвшинд ажиллаж байгаа гадаадын мэргэжилтнүүдийн хэмжээнд хүргэх шаардлага тавина.

3.5.6 Иргэдийн төлж байгаа бүх төрлийн НДШ-ийг тухайн даатгуулагчийн нөрийн дансанд төвлөрүүлэх, хүү тооцох, өвлүүлэх, ажилгүйдлийн, гэнэтийн ослоы даатгалын шимтгэл зэргийн ашиглагдаагүй үлдэгдлийг тэтгэврийн даатгалын санд шилжүүлэх зэргээр даатгалын тогтолцоонд бүтцийн өөрчилөлт хийнэ.

### **3.6 АХМАД НАСТАН**

3.6.1 Өндөр насны тэтгэврийг үнэ ханшийн өөрчилөлт, улс орны эдийн засгийн нооц боломжийг харгалзан жилд 2-оос доошгүй удаа нэмэгдүүлж тэтгэврийн зөрүүг арилгана.

3.6.2 Монгол улсын тусгаар тогтнол, бүтээн байгуулах үйлсэд онцгой хувь нэмэр оруулсан алдар гавьяатай хүмүүст төрөөс үзүүлэх бүх төрлийн хөнгөлөлт тэтгэмжийг 5 дахин нэмэгдүүлнэ.

3.6.3 Ахмад настны нийтийн унаа, эм тарианы болон үнийн өсөлтөөс хамгаалах нөхөн олговрыг улирал тутамд бодож өгч байна.

3.6.4 Тэтгэврийн насны ахмадуудыг жилд нэг удаа үнэ төлбөргүй эмнэлэгийн иж бүрэн үзлэгт хамруулна.

3.6.5 Асран хамгаалах хүнгүй өндөр настанд зориулсан асрамжийн газруудыг бүсүүдийн төвүүдэд бий болгож төрөөс бүх зардлыг хариуцна.

### **3.7 ХҮҮХЭД, ЭМЭГТЭЙЧҮҮД, ЗАЛУУЧУУД**

3.7.1 Өрх толгойлсон, ажилгүй 2-оос дээш хүүхэдтэй эмэгтэйчүүдэд төрөөс сар бүр гэнгэлэг олгоно.

3.7.2 Айлын гурав дахь буюу түүнээс дээш хүүхэд бүрийн 16 нас хүртэл хэрэглэх хоол хүнс, хичээл, сургуультай холбоотой эцэг эхээс гарах зардлын жишгийг тогтоож төрөөс хариуцна.

3.7.3 Хүүхэд бүрт сард 20,0 төгрөг олгоно.

3.7.4 Өнчин тэнэмэл хүүхдийг төр шууд ивээлдээ авч, нэг ч хүүхдийг орхилгүй сургаж хүмүүжүүлэх арга хэмжээ авна.

3.7.5 Нийгмийн халамж, хамгааллын салбарыг эмэгтэй хүнээр удирдуулах бодлого баримтална.

3.7.6 Шинээр гэр бүл болсон залуучуудад ажил, бизнес, орлого олж байгаа эсэх, нас харгалзахгүй ирээдүйд олох орлогоор барьцаалсан хямд үнэтэй орон сууцаар хангах хөтөлбөр хэргжүүлнэ.

3.7.7 Чухал шаардлагатай нарийн мэргэжлүүдээр гадаадын нэр хүндтэй их дээд сургуульд төр болох хувийн хэвшлийн захиалгаар суралцах явдлыг дэмжин урамшуулна. Гадаадад ажиллаж амьдарч байгаа чадварлаг залуучуудыг эх орондоо ирж ажиллах нөхцлийг бүрдүүлнэ.

3.7.8 Гадаадад суралцаж байгаа оюутнуудыг дэмжих төрийн сургалтын сангийн гүүлд гоц авьястай хүүхдүүдийг эхний ээлжинд хамруулна.

3.7.9 Хоёр ба түүнээс дээш ихэр хүүхдийн халамж, асаргаанд зориуж төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлнэ

## **3.8 АМЬДАРЛЫН БАТАЛГААГ ХАНГАХ**

3.8.1 Улаанбуудай, цагаан будаа, мах, төмс, хүнсний ногоо, хуурай сүү гэсэн таван төр төрлийн хүнсний бараагаар улсын нөөц бий болгох, энэ зориулалтаар улсын нөсвөөс хөрөнгө гаргаж, дээрхи хүнсний барааны үнийг төрөөс зохицуулж, үйлдвэрлэгч, импортлогч дотоодын компаниудыг татвараас 100 хувь чөлөөлнө.

3.8.2 Иргэн бүрт газар өмчлүүлэх үзэл санааг дэмжинэ. Газраа өмчилж авсан иргэд хоорондоо хамтран Газар өмчлөгчдийн холбоог байгуулж түүгээрээ дамжуулан илэнцэрийнхээ амьдарлын баталгааг хангах, орон сууцтай болох, хөрөнгө оруулагчидтай хамтран ажиллах санаачлагыг төрөөс бүх талаар дэмжинэ.

3.8.3 Стратегийг ач холбогдол бүхий орд газруудын Монголын талд ноогдох хэсгийг хувьцаат компани болгож тодорхой хэсгийн ард түмэндээ хувьцаа хэлбэрээр тарааж иргэдээ өмч хөрөнгөтэй болгох үзэл санааг дэмжинэ. Иргэд хувьцааныхаа ноогдол ашгийг авахаас өөрөөр бусдад шилжүүлэх, зарах, бэлэглэхийг хориглох ба зөвхөн өөрийн үр хүүхэд төрөл садандаа өвлүүлэхийг ивээнхөөрөх хуулийн тогтолцоог бий болгоно.

## **ДӨРӨВ. УЛААНБААТАР ХОТЫН ХӨГЖЛИЙН ТАЛААРХИ ЗОРИЛТ**

*Монголын хүн амын тал хувь нь буюу 1,2 сая гаруй хүн ажиглаж амьдарч байгаа Улаанбаатар хот бүхэлдээ хот төлөвлөлт, байгаль экологи, эрүүл ахуйн хувьд гамшигийн байдалд хүрч ачааллаа даахаа болиод байна.*

## 4.1 ЭРҮҮЛ, ТОХИЛОГ УЛААНБААТАР

4.1.1 Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах, хог хаягдлыг багасгах зорилгоор “Экологид ээлтэй 100,0 мянган гэр” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Энэ хөтөлбөрийн хүрээнд коксжсон утаагүй нүүрс, гэр хорооллын айл өрхийг цахилгаанаар халаах зуухаар хангаж өвлийн улиралд хэрэглэсэн цахилгааны үнийг төрөөс хариуцна.

4.1.2 Хотын хэт төвлөрлийг сааруулж Налайх дүүрэг, Багануур дүүрэг, Зуунмодод цагуул хотуудыг шинээр төлөвлөн байгуулж энд газрыг иргэдэд хуваарилах, төрийн захиргааны зарим байгууллагуудыг байршуулах, худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, аялал жуулчлалын том төвүүдийг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар байгуулна.

4.1.3 Аялал жуулчлалын томоохон цогцолбор, барилгын материалын үйлдвэрлэлийн паркыг Найлайх дүүрэгт, нүүрс болон бусад боловсруулах үйлдвэрлэлийн паркыг Багануур, Багахангай дүүргүүдэд байршуулах замаар төвлөрлийг сааруулах цогц бодлого хэрэгжүүлнэ.

4.1.4 Гэр хорооллыг дахин төлөвлөх, газараа өмчилж авсан иргэд холбоо байгуулах замаар газраа барьцаалан хөрөнгө оруулагчидтай тохиролцон амьдрах орчноо сайжруулах санал санаачлагыг дэмжин хууль эрх зүйн тааламжтай орчин бүрдүүлнэ.

4.1.5 Орон сууцны санхүүжилтийн корпорацыг “Орон сууцны санхүүжилтийн банк” болгож, орон сууцанд хөрөнгө оруулах сонирхолтой гадаад дотоодын хөрөнгө оруулагчид, хөрөнгө оруулалтын томоохон сангууд, Засгийн газрыг бонд, үгүйс цаас зэргийн санхүүжилтийг төвлөрүүлж, Монгол улсын хөгжүүлэх сангийн хөрөнгө, нийгмийн даатгалын сангуудын илүүдэл хөрөнгө зэргийг байршуулан Улаанбаатар ходод ойрын 8 жилд багтаан 150 мянгаас доошгүй айлын орон сууц барих боломжийг бүрдүүлнэ. Иргэдийг жилийн 5 хувиас хэтрэхгүй хүүтэй 20-30 жилийн урт хугацаатай зээлийн орон сууцаар бүрэн хангана.

4.1.6 Хот орчимд өндөр ашиг шим бүхий хөдөө аж ахуйн бүтээгдхүүн үйлдвэрлэдэг фермерүүдийг олноор байгуулж хотын хүнсний бүтээгдхүүний хөрөнцээг эрүүл хүнсээр бүрэн хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

## ТАВ. УЛС ТӨРИЙН ЗӨРИЛТ

*Эх орон нам төрийн бүтцийг зөв, боловсронгуй болгоно.*

Эх орон нам ардчилал, эв нэгдэл, хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулж, шударга, ажил хэрэгч, эрх зүйт төрийн тогтолцоог төлөвшүүлнэ.

## 4.1 ТӨРИЙН ТОГТОЛЦООГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ

4.1.1 Төрийн эрх мэдлийн хуваарилалтыг боловсронгуй болгож, тэдгээрийн харилцан бие биеэ дэмжих чанарыг дээшлүүлнэ. Хоёр танхимтай парламентын төлөөлөлийн үзэл санааг дэмжинэ.

- 5.1.2 Байнгын ажиллагаатай мэргэжлийн цомхон парламентыг бүрдүүлэх нь Монгол орны өнөөгийн нөхцөлд илүү тохиромжтой гэж үзнэ.
- 5.1.3 Шүүх тогтолцоо нь Засгийн газар болон хууль тогтоох байгууллагаас бүх талаар хараат бус ажиллах арга механизмыг бий болгоно. Хууль хяналтын байгууллагад шинэтгэл хийнэ.
- 5.1.4 Эдийн засгийн хувьд бүс нутаг бүр бие даан хөгжих нөхцөл боломжийг бүрдүүлж, нутгийн өөрөө удирдах ёсыг жинхэнэ ёсоор төлөвшүүлнэ.
- 5.1.5 Нийслэл, аймаг, сум, дүүргийн ИТХ-д иргэний нийгмийн байгууллагуудаас ирдэвчлүүлэх, оролцох боломжийг хуулийн хүрээнд бий болгоно.
- 5.1.6 Аймаг, нийслэлийн Засаг даргыг иргэд нь сонгодог болгоно.
- 5.1.7 Сонгуулийн пропорциональ системийг дэмжинэ.

## **5.2 ТӨРИЙН АЛБАДЫН ЦОМХОН ЧАДВАРЛАГ БҮТЦИЙГ БҮРДҮҮЛЭХ**

- 5.2.1 Засгийн газрын агентлагуудын ажлын давхардлыг арилгаж, зарим агентлагийн үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлнэ.
- 5.2.2 Яамдыг үйл ажиллагааны чиглэлээр ажиллуулж мэргэжлийн хүнээр удирдуулна.
- 5.2.3 Төр засгийн боловсон хүчнийг шилж сонгохдоо намын харъяаллыг бус мэргэжлийн чадварыг эн тэргүүнд чухалчилан үзнэ.

## **5.3 АВИЛГА, ХЭЭЛ ХАХУУЛЬ, ХУЙВАЛДААНЫГ АРИЛГАЖ, ГЭМТ ХӨРГИЙГ БУУРУУЛАХ**

- 5.3.1 Бүх төрлийн лиценз, зөвшөөрөл олгодог журмыг хялбар болгон тоог цөөрүүлж шат дамжлага, чирэгдлийг арилган, иргэдийн хяналтыг хүчтэй болгоно.
- 5.3.2 Бүх шатны шүүгчид, прокурор бусдын нөлөөнд автахгүй байх нөхцөлийг бүрдүүлж, амьдарлын баталгааг нь хангана. Төрийн албан хаагчдын албан тушаал ахихын хэрээр илүү хариуцлага хүлээдэг зарчмыг хэвшүүлнэ.
- 5.3.3 Хоорондоо зөрчилтэй хууль, тогтоомжуудыг нэгтгэн цэгцэлж уялдаа холбоог хангана. Хуулийн хэрэгжилтэд тавих бүх шатны хяналтыг өндөржүүлнэ.
- 5.3.4 Гэмт хэргийн тоог эрс бууруулж, зохион байгуулалттай гэмт хэрэг гарах нийгэм, эдийн засгийн үндсийг арилгана.
- 5.3.5 Ял эдлэгчдээр бүтээх хөдөлмөр хийлгэн улс, байгууллага, иргэдийг эдийн засгийн хувьд хохиролгүй болгох чиглэлийг голлон баримтална.
- 5.3.6 Ард түмнээ үнэн бодит мэдээллээр хангадаг чөлөөт хэвлэлийг дэмжинэ. Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдийн эрхийг хамгаалах тогтолцоог бүрдүүлнэ.

## **5.4 ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ**

- 5.4.1 Нээлттэй, олон тулгуурт гадаад бодлогыг эрхэмлэнэ

- 4.2 Хөрш хоёр улстайгаа тогтоосон уламжлалт харилцааг хүндэтгэн үзэж, харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлнэ.
- 4.3 Үндэсний аюулгүй байдлыг хангах гөл арга зам нь хараат бус хүчтэй эдийн засгийг бүрдүүлэх явдал гэх үзнэ.
- 4.4 Улс төрийн намуудын харилцаанд үндэсний язгуур эрх ашиг, эв нэглийн төлөө зөвшилцөх, ойлголцох зарчмыг чухалчилна.
- 4.5 Хилийн цэргийн зохион байгуулалт, мэргэжлийн чадварыг дээшлүүлж, зэвсэг, техник хэрэгслэл, хил хамгаалалтын хамгийн орчин үеийн түвшинд шийдвэрлэнэ. Цомхон, чадварлаг, мэргэжлийн завсагт хүчинтэй байх бодлого баримтална.

### **ЭХ ОРОН НАМААС 2008-2012 ОНД ШИНЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРҮҮД**

1. Гэр хорооллыг орон сууцжуулах “Ардын орон сууц” хөтөлбөр
2. Гэр хороололд хүүхдийн цэцэрлэг барих “Цэцэрлэг” хөтөлбөр
3. “Эрүүл Улаанбаатар” хөтөлбөр
4. “Нүүрс” үндэсний хөтөлбөр
5. “Газар өмчлөл” үндэсний хөтөлбөр
6. “150,0 мянган айлын орон сууц үндэсний хөтөлбөр
7. “180,0 мянган ажлын байр” үндэсний хөтөлбөр
8. “Иргэний нийгэм” үндэсний хөтөлбөр
9. “Уламжлалт технологи-Дэлхийн зах зээлд” үндэсний хөтөлбөр
10. “Амьдрах аюулгүй орчин” үндэсний хөтөлбөр
11. “Электрон засаглал” үндэсний хөтөлбөр
12. “Төрийн үйлчилгээг нэг цэгээс үндэсний хөтөлбөр
13. “Хүн амын төвлөрөл” үндэсний хөтөлбөр
14. “10,0 мянган бичил үйлдвэр” үндэсний хөтөлбөр

### **ЭХ ОРОИ НАМААС 2008-2012 ОНЫ УИХ-Д ОРГӨН БАРИХ ХУУЛИЙН ТОСЛУУД**

1. Малчны тухай хуулийн төсөл
2. Газар өмчлөгчдийн хөлбооны тухай хуулийн төсөл
3. Архи спиртийн үйлдвэрлэлд хяналт тогтоох тухай хуулийн төсөл
4. УИХ-ын сонгуулийн тухай хуулийн төсөл
5. Орон нутгийн сонгуулийн тухай хуулийн төсөл
6. Гэр бүлийн хөгжил, хамгааллын тухай хуулийн төсөл
7. Экопаркийн тухай хуулийн төсөл
8. Аж үйлдвэрийн паркын тухай хуулийн төсөл



**ЭХ ОРОН НАМ**